



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/10/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Х.Еркебулан

Утас: 70423073 Цахим хаяг: akon_erka@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	7
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.12	Шилэн дансны мэдээлэл	14
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3	Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24

1 Аудитын гэрчилгээ



БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.БАУЫРЖАН ТАНАА

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: 70422954, 70422930

2014.02.24 № 51 БДТ-Б/10/07-ТТЗ
танай _____-ны № _____-т

Г Аудитын гэрчилгээ 7

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу УАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Булган сумын Засаг дарга Ж.Бауыржан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2, 8.9.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Булган сумын ТТЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Булган сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.09-нээс 2017.03.20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор Х.Еркебулан хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.05-нд төрийн аудитын байгууллагад 2017.03.03-ны өдрийн 52-р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Булган сумын ТТЗ *“Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,*

харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнхээ санхүүгийн байдал, хүн амын орлого, хөдөлмөрийн нөөц, газрын төлөв байдлын удирдлага, төлөвлөлттийг хангахад шаардагдах тайлан тэнцэл гаргах, тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих,

хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Булган сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ.

Булган сумын ТТЗ-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Булган сумын ТТЗ-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох

бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Булган сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Булган сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Булган сумын ТТЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 10 асуудал эрсдэл өндөр, 0 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 30 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 10 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Орон нутгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан тул нийт хөрөнгийг материаллаг байдлыг тооцох суурь үзүүлэлтээр сонгох нь тохиромжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Булган сумын ТТЗ-ийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгө 5860.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 58.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дотоод хяналт хэвийн гэж үзсэнтэй холбоотой юм. Чанартай холбоотой асуудал байхгүй.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 10 эрсдэлтэй асуудалд 10 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа, зөрчил илэрээгүй. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад Орон нутгийн хөгжлийн сангаас дутуу олгосон 18,3 сая төгрөгийн санхүүжилтийг авлагаар тусгаж харуулаагүй, ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 31,4 сая төгрөгийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй зөрчлийг залруулж ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тайлант онд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас дутуу олгосон 18,3 сая төгрөгийн санхүүжилтийг санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй, ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 31,4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсныг санхүүгийн тайланд залруулга хийж, алдаа зөрчилд тооцов.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил гараагүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага өгөг алдаа зөрчил гараагүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сахилгын шийтгэл ногдуулах асуудал гараагүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

ОНХС, СХСангийн авлага, өглөгийн бүртгэл тооцоо, баталгаажуулалт.

2.11 Төсвийн гүйцэтгэл, САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал**

/төгрөгөөр/

Данс ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	120351755.43	157522891.66	37171136.23
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	120351755.43	157522891.66	37171136.23
3121	Төгрөг	120351755.43	157522891.66	37171136.23
31211	Төрийн сангийн харилцах	120328138.43	157509025.43	37180887.0
31213	Арилжааны банк дахь харилцах	23617.0	13866.23	9750.77

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 157.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0.09 сая төгрөг нь арилжааны банкинд дахь, 157.5 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны

үлдэгдлийн 104.1 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны, 13.1 сая төгрөг нь СХСангийн дансны, 40.3 сая төгрөг нь ОНХСангийн дансны үлдэгдэл байна.

Арилжаны банкинд байгаа 13.8 мянган төгрөгийн ЗДТГ-ын дансны үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
33	АВЛАГА	270293750.00	268231410.00	-2062340.00
335	Бусад авлага	956000.00	853000.00	-103000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага		18300000.0	18300000.0
3351	Байгууллагаас авах авлага	208000.00	208000.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	748000.00	645000.00	103000.00
336	Зээлийн авлага	269337750.00	249078410.00	-43070656.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	269337750.00	249078410.00	-43070656.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	269337750.00	249078410.00	-43070656.00

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 2.1 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны эхнээс 43.1 сая төгрөгөөр буурсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр гарын үсэг зуруулж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. ОНХСан 18.3 сая төгрөгний санхүүжилтийн авлагатай гарсан байна.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	257652421.18	279110565.42	21458144.24
351	Түүхий эд материал	6935322.28	6396012.28	-539310
354	Хангамжийн материал	250717098.90	272714553.14	21997454.24

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 21.4 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 2.3 хувь нь түүхий эд материал, 97.7 хувь нь хангамжийн материал байна. Тайлант онд нийтдээ 0.8 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5155784071.73	5174347263.61	18563191.88
391	Газар			0.00
392	Биет хөрөнгө	5153747962.01	5172685738.69	18937776.68
393	Биет бус хөрөнгө	2036109.72	1661524.92	-374584.80

Үндсэн хөрөнгө оны эхнээс 18.6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 43.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 233.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 258.1 сая төгрөгийн элэгдэл тооцож, данснаас хассан үндсэн хөрөнгийн 15.8 сая төгрөгний элэгдэлийг данснаас хасалт хийсэн байна.

Төсөвт байгууллагууд нийтдээ 233,0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 158.2 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 10.7 сая төгрөгийн, ЭМТөв 42.7 сая төгрөгийн, Ёлтын бага сургууль 10.3 сая төгрөгийн, Шүвтэр бага сургууль 3.5 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 16.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

5.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>25531492.00</u>	<u>42095475.00</u>	<u>16089020.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>25531492.00</u>	<u>42095475.00</u>	<u>16089020.00</u>
413	Өглөг	<u>25531492.00</u>	<u>10695475.00</u>	<u>16089020.00</u>
4136	Бусад өглөг	<u>25531492.00</u>	<u>42095475.00</u>	<u>16089020.00</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	11003920.00	4438312.00	6565608.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	14527572.00	37182200.00	22654628.00

Төсөвт байгууллагуудаас оны эхэнд Ёлтын бага сургууль 1.8 сая төгрөгийн, Ёлтын хүүхдийн цэцэрлэг 0.4 сая төгрөгийн, Хүн эмнэлэг 1.9 сая төгрөгийн, ЗДТГазар 19.2 сая төгрөгийн, Сумын хүүхдийн цэцэрлэг 1.1 сая төгрөгийн, ИТХурал 1.2 сая төгрөгийн нийтдээ 25.6 сая төгрөгөөр өглөгтэй байна.

Оны эцэст Ёлтын бага сургууль 2.8 сая төгрөгийн, Ёлтын хүүхдийн цэцэрлэг 1.8 сая төгрөгийн, Хүн эмнэлэг 5.9 сая төгрөгийн, ЗДТГазар 0.2 сая төгрөгийн, ОНХСан 31.4 сая төгрөгийн нийтдээ 42.1 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Улсын төсвийн санхүүжилт

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 2523.7 сая төгрөгийн санхүүжилт, 101.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 328.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 117.9 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 101.7 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Булган сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 1280.0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 695.9 мянган төгрөгийн орлого оруулж, 584.1 мянган төгрөгөөр тасалдуулсан байна.

6.4 Татварын орлого

Булган сумын ИТХ-аас сумын 2016 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 45.6 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 29.6 хувийг ХАОАТатвараас, 52.6 хувийг бусад татвараас, 17.8 хувийг татварын бус орлогоос оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /төгрөг/

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
Нийт орлогын дүн	45628000.0	117869441.0	72241441.0	258.3%
Татварын орлого	45603000.0	117374441.0	71771441.0	257.4%
ХАОАТатвар	13500000.0	27082339.0	13582339.0	200.6%
Өмчийн татвар	8130000.0	5790000.0	-2313000.0	90.3%
Бусад татвар	24000000.0	84502102.0	60502102.0	352.1%
Татварын бус орлого	25000.0	300000.0	275000.0	1200.0%
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	25,000	300000.0	275000.0	1200.0%

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 117.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 72.2 сая төгрөгөөр буюу 158.3 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 99,6 хувийг татварын орлогоос, 0,4 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатварыг 13,5 сая төгрөгөөр буюу 100.6 хувиар, бусад татварыг 60,5 сая төгрөгөөр буюу 2,5 дахин давуулан биелүүлж, өмчийн татвар 2,3 сая төгрөгөөр буюу 9,7 хувиар тасарчээ. Бусад татвараас агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 63,6 сая төгрөгийн орлогыг төлөвлөснөөс илүү оруулсан нь төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 91.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 117.8 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 104,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 158051.2 мянган төгрөгийн орлогыг оруулж, аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Газрын төлбөрөөс 706.1 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвараас 890,4 мянган төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 133.6 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 20.3 сая төгрөгийг, Эргэлтийн эмийн санд 2.5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Булган сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ **3142.1** сая төгрөгийн төсөв батлагдсаны 2525.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 465.1

сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 151.9 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 1.3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2524.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 465.2 сая төгрөгийн, ОНХСанд 133.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, бүгд дүнгээр 3123.2 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 19.0 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь ОНХСанд төсвөөс олгох санхүүжилт 18.3 сая төгрөгөөр дутуу олгогдож, ОНХСангийн санхүүжилтээс 31.4 сая төгрөгийг зарцуулаагүй үлдэгдэл гарсан, төсөвт байгууллагуудаас 21.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой. БДСургууль 6.4 сая төгрөгийн, ЭМТөв 2.6 сая төгрөг, Шүвтэр бага сургууль 1.4 сая төгрөг, Ёлт бага сургууль 8.7 сая төгрөг, Ёлт хүүхдийн цэцэрлэг 1.1 сая төгрөг, Соёлын төв 1.0 сая төгрөгийг нийтдээ төсөвт 21.2 сая төгрөг төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3142.2	3070.9	97.7%	71.2
1.1	Урсгал зардал	3142.2	3070.9	97.7%	71.2
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	3142.2	3070.9	97.7%	71.2
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	2523.8	2503.3	99.2%	20.4
2.2	Орон нутгийн төсвөөс	465.2	433.3	93.1%	31.9
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	151.9	133.6	88.0%	18.3
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	1.3	0.7	53.8%	0.6

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сумын ИТХурал	83142800	58733900	24408900	70.6%
Сумын ЗДТГазар	382031600	374657245	7374355	98.0%
Бүрэн дунд сургууль	1258320900	1251913668	6407232	99.5%
Эрүүл мэндийн төв	427955200	426070978	1884222	99.6%
Хүүхдийн цэцэрлэг	226645800	226645800	0	100.0%
Соёлын төв	54793700	53157388	1636312	97.0%
Ёлт бага сургууль	181141800	172472511	8669289	95.2%
Ёлт хүүхдийн цэцэрлэг	100070500	98979945	1090555	98.9%
Шүвтэр бага сургууль	276148600	274764020	1384580	99.5%

ОНХСан	151900000	133600000	18300000	88.0%
Бүгд	3142150900	3070995455	71155445	94.6%

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлуудыг 2.8-7.0 сая төгрөгөөр хэмнэж, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардлуудыг 0.8-4.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Үзүүлэлт	Тайлант оны		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		120351755.4	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3142150900.0	3070995455.0	71155445.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1943228200.0	1940413753.0	2814447.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217344300.0	211101690.0	6242610.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185590400.0	186170843.0	-580443.0
Хангамж, бараа материалын зардал	92460100.0	91316468.0	1143632.0
Нормативт зардал	245662100.0	242401719.0	3260381.0
Эд хогшил, урсгал засварын зардал	25788200.0	28316180.0	-2527980.0
Томилолт, зочны зардал	10752500.0	15566350.0	-4813850.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47987000.0	40332157.0	7654843.0
Бараа үйлчилгээний бусад зардал	39434200.0	32029450.0	7404750.0
Бусад урсгал шилжүүлэг	182003900.0	149746845.0	32257055.0

7.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 101.7 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 99.1 сая төгрөгийг зарцуулж, 2.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

7.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт

Булган сумын 7 төсөвт байгууллага тусгай зориулалтын шилжүүлгээр 2523.8 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдсөнөөс 2503.3 сая төгрөгийн санхүүжилтийг 20.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

7.4 Сангийн зарцуулалт

Булган сумын ОНХСан нь оны эхэнд 27.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 133.6 сая төгрөгийн санхүүжилт авч, 120.6 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 40.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 20.3 сая төгрөгийн орлогыг оруулсан ба тайлант онд зээл олгоогүй, оны эцэст 13.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСан нь жилийн эцэст 249.1 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

